

Есдугээр зуйл

Энэ гэрээний 8-р зуйл нь консульш гэргий, тууний хама? амьдарч байгаа насанд хурээгүй хуухдуудэд нэгэн адил хамаарна.

-III-

Консулын үүрэг

Аравдугаар зуйл

1. Консул нь томилсон улс, тууний иргэдийн эрх ашиг, сонирхлыг хамгаалка. /Иргэд ба хуулийн этгээд/

2. Консул уургээ гуйцэтгэхдээ өөрийн консульш тойрог дахь улсын байгууллагуудтай харилцах бөгөөд томилсон улс, тууний иргэдийн эрх, ашиг сонирхолд ул нийцэх зөрчлийн талаар энэ байгууллагуудад эсэргууцэл тавьж болно.

Суугаа орны төв байгууллагуудтай харилцаа барих эрхийг дипломат төлөөлөгчдийн газраар дамжуулан гуйцэтгэнэ.

Арван нэгдүгээр зуйл

Консул нь тойрогтоо байнга буюу тур оршин суугаа томилсон улсын иргэдийг бургтэх эрхтэй.

Арван хоёрдугаар зуйл

1, Консул нь томилсон улсын иргэдэд паспорт олгох эрхтэй.

2. Консул нь томилсон улсад орох буюу мөн туунээс тарах виз олгоно.

Арван гуравдугаар зуйл

Консул нь томилсон улсын харьяат болохыг хуссэн өрөгдлийг бусад улсын иргэд, аль ч улсын харьяат бипг хумуусээс хулээн авна.

Арван дөрөвдүгээр зуйл

Хэрэв суугаа орны хууль зуйд харшлахгүй бол консул сууцандаа буюу өөрийн улсын иргэдийн сууцанд мөн улсынхаа далбаа бухий онгоцон дотор дор дурдсан ажил хэргийг явуулах эрхтэй.